

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН
ЦЭГ БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ,
ХААХ АРГАЧИЛСАН ЗААВАР**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү Аргачилсан зааврын зорилго нь энгийн хатуу хог хаягдлыг төвлөрүүлж, булшлах зөвшөөрөгдсөн газар болох төвлөрсөн хогийн цэг байгуулах, тавигдах шаардлага, хогийн цэгийн төрөл, явуулах үйл ажиллагаа, төвлөрсөн хогийн цэгийг хэсэгчлэн болон бүрэн хаах, түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ Аргачилсан заавар нь Хог хаягдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

1.3. Энэ Аргачилсан зааврыг Монгол улсын нутаг дэвсгэр дээр хог хаягдал үүсгэгч этгээд болон Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9.б-д заасан бүртгэл хийлгэсэн, энгийн хатуу хог хаягдал сэргээн ашиглах, устгах, булшлах зорилгоор хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (цаашид Эрх бүхий этгээд гэх) дагаж мөрдөнө.

1.4. Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах, шатаах ангиллаас үлдсэн доорх нэр төрөл бүхий хог хаягдлыг булшилж устгана. Энэ Аргачилсан зааварт зохицуулсан хог хаягдал нь зөвхөн энгийн хатуу хог хаягдалд хамаарна.

1.4.1. Нүүрс, модны үнс; /асуух-ашиглаж болно гэж үзэж байна.

1.4.2. Түргэн муудах хоол, хүнс, ахуйн хаягдал;

1.4.3. Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдал;

1.4.4. Байгаль орчинд сөрөг нөлөөгүй мал, амьтны сэг зэм, ургамлын хог хаягдал;

1.4.5. Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал;

1.4.6. Боловсруулсан дахин ашиглах боломжгүй бохир хөрс, шороо, чулуу, элс, хайрга;

1.4.7. Хаягдал халдваргүйжүүлэх төхөөрөмжөөс гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал, далан, усан сангийн лав /үйлдвэрийн цэвэрлэх байгууламжаар гарах лаваас бусад/;

1.4.8. Ахуйн болон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний дахин ашиглах боломжгүй, аюулгүй хог хаягдал;

1.4.9. Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал

1.5. Улс, нийслэл болон орон нутгийн зэрэглэлтэй хот нь хог хаягдал булшлах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгтэй байх бөгөөд төвлөрсөн цэг ажиллуулах зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр олгоно.

1.6. Энэ Аргачилсан зааврын 1.5-д зааснаас бусад тосгон, төвлөрсөн суурин бүр хог хаягдал булшлах, устгах цэгтэй байх ба хогийн цэгийн зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгоно.

1.7. Төвлөрсөн цэг болон орон нутгийн шинжтэй хогийн цэг үйл ажиллагаандаа энэхүү Аргачилсан зааврыг дагаж мөрдөнө.

1.8. Төвлөрсөн хогийн цэгийг хэсэгчлэн болон бүрэн хаах, хаасны дараа энэ зааврын 4.4.1-д заасан хугацаанд гарах зардлыг Эрх бүхий этгээд болон ландфилл хаах этгээд бүрэн хариуцна.

ХОЁР. ТӨВЛӨРСӨН ЦЭГ БАЙГУУЛАХ

2.1. Хог хаягдал булшлах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн хогийн цэг Хог хаягдлын тухай хуулийн 17, 18-р зүйлд заасан шаардлагыг хангасан байхаас гадна байршил нь дараах шалгуурыг хангасан байна:

2.1.1. Хүн амын суурьшлын хэтийн бүсийн гадна орших (суурьшлын шинэ бүсээс улс, нийслэлийн зэрэглэлтэй хот бол 30 км, орон нутгийн зэрэглэлтэй хот, төвлөрсөн суурин газар бол 10 км-ээс доошгүй зайд байна);

2.1.2. Тухайн хот, суурин газрын уур амьсгалын төлөв байдалд сөрөг нөлөөгүй байх, нөлөөгүй тухай дүгнэлт гарсан байх;

2.1.3. Хүрээлэн буй орчин, хөрсний үржил шим, геологи, газар зүйн тогтоц нь судлагдсан байх;

2.1.4. Зам, шугам сүлжээний болон улс, нийслэл, орон нутгийн зориулалтаар ашиглагдахгүй газар байх;

2.1.5. Газрын гадаргын болон гүний усны нөөц бүхий газраас ангид байх;

2.1.6. Түүх, соёлын дурсгалт болон байгалийн өвөрмөц тогтоц бүхий газартай давхцаагүй байх, эдгээр газраас алс буюу 10 км-ээс доошгүй газарт байх;

2.1.7. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр иргэн, аж ахуйн нэгжийн эдэлбэрийн зориулалтаар ашиглахаар хуваарилагдсан газраас ангид байх;

2.1.8. Хаягдлын эх үүсвэр болон хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, дахин ашиглах, шатаах байгууламжтай ойр байх;

2.2. Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, цэгийн байршлыг тогтоох асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргын Захирамжаар шийдвэрлэх ба орон нутгийн байгаль орчны үнэлгээний шинжээч болон газар, ус, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн үнэлгээ, дүгнэлт, зөвлөмжийг үндэслэнэ.

2.3. Энэ зааврын 2.2-д заасан мэргэжилтнүүдийн дүгнэлт дутуу тохиолдолд батлан гаргасан аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжийг хүчингүйд тооцно.

2.4. Төвлөрсөн цэг байгуулахаар сонгосон газарт аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж гарахаас өмнө байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэнэ.

2.5. Хог хаягдлын төвлөрсөн цэгийн зэрэглэлийг хүчин чадал, зориулалт, хоногт хүлээн авах хог хаягдлын хэмжээ, бүтэц, хог хаягдал булшлах, устгах газрын гүн, талбайг үндэслэн гаргаж, засварын газар, жингийн тавцан, хучлага хөрс хураах газрын хэмжээ зэрэг хогийн цэгийн талбайн нэмэлт хэрэгцээг үндэслэн тооцно.

ГУРАВ. ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГИЙН ЯВУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Хог хаягдлын тухай хуулийн 17.2-т заасны дагуу төвлөрсөн цэгийг гурван зэрэглэлээр ангилах ба тухайн төвлөрсөн цэгийн зэрэглэлийг аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэрээр тогтооно. Төвлөрсөн цэгийн зэрэглэлийг тогтоохдоо дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ.

3.1.1. Төвлөрсөн цэгийн талбайн хэмжээ,

3.1.2. Хүлээн авах хог хаягдлын хэмжээ, хүчин чадал

3.1.3. Тухайн орон нутгийн хог хаягдал зайлуулах хэрэгцээ шаардлага

3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 17.3-д заасан стандартын шаардлага

3.2. Төвлөрсөн хогийн цэг болон энгийн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламжид Эрх бүхий этгээд Хог хаягдлын тухай хуулийн 18.2, 18.3-д заасан үйл ажиллагааг эрхлэхээс гадна дараах үйл ажиллагааг эрхэлж болно:

3.2.1. Хог хаягдлыг ангилах,

3.2.2. Холбогдох норм, дүрэм стандартын дагуу хог хаягдлыг булшлах,

3.2.3. Хог хаягдлыг дахин сэргээх, дахин ашиглах, дахин боловсруулах, шатаах үйлдвэр ажиллуулах, үйл ажиллагаа эрхлэх,

3.2.4. Ангилсан хог хаягдлыг түүхий эд болгон дахин сэргээх, дахин ашиглах, дахин боловсруулах, шатаах үйл ажиллагаа эрхлэгчид нийлүүлэх, экспортлох,

3.2.5. Ирсэн хог хаягдлын төрөл, зүйлийг шалгаж, зөвшөөрөгдсөн хог хаягдал мөн эсэхэд тухай бүр дүгнэлт гаргах,

3.3. Төвлөрсөн хогийн цэгт дараах үйл ажиллагааг хориглоно.

3.3.1. Дахин сэргээх, дахин ашиглах, дахин боловсруулах, шатаах боломжтой болон аюултай хог хаягдлыг булшлах,

3.3.2. Мэргэжлийн хяналтын зөвшөөрснөөс бусад үхсэн малын сэг, зэм, ургамлыг булшлах,

3.3.3. Хог хаягдал булшлах үйл ажиллагааг хэт өндөр дуу чимээ, тоос, шороо, манан, орчны бохирдол үүсгэж булшлах,

3.3.4. Төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөлгүй хүн, амьтан, мал, техник хэрэгсэл оруулах

3.4. Дахин сэргээх, дахин ашиглах, дахин боловсруулах, шатаахаас үлдсэн булшлахаас өөр аргагүй хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт булшилна.

3.5. Булшлах хог хаягдлыг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор нягтруулан дагтаршуулж, хөрсөөр булна.

3.6. Булшлах хог хаягдлыг хог хаягдлын шинж чанар, байдлаас хамаарч, жижигсгэх, шахах, эзэлхүүнийг багасгах бүх арга хэмжээг авсны дараа булшилна.

3.7. Мэргэжлийн байгууллагаас ирсэн зарим төрлийн энгийн, тусгай хог хаягдлыг халдваргүйжүүлэх, аюулгүйжүүлэх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулах арга хэмжээ авсны дараа энэ зааврын 1.4, 3.3.1-д заасныг баримтлан булшилна.

3.8. Байгууламж, төвлөрсөн цэгийн ажиллах дүрэм, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны заавар, цагийн хуваарь, ажиллах хүч, техник хэрэгслийн хөдөлгөөний хуваарь зэргийг Эрх бүхий этгээд баталж мөрдүүлнэ.

3.9. Байгууламж, төвлөрсөн цэгийн эргэн тойронд 500 метрийн зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүс тогтоож, уг бүсэд хүн ам оршин суух, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх, барилга барих зэрэг аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

3.10. Төвлөрсөн хогийн цэгийн үйл ажиллагааны нарийвчилсан болон дотоод зохицуулалт, зохион байгуулалтыг Хог хаягдлын тухай хуулийн 9.1.3, 9.3.2-т заасан журмаар нарийвчлан зохицуулна.

3.11. Хог хаягдлын шинж чанар, зэрэглэлээс хамааруулан төрөлжүүлэн ангилах, устгах үйл ажиллагааг технологийн дагуу тусгаарлагдсан орчинд явуулах нөхцлийг Эрх бүхий этгээд хангасан байна.

3.12. Төвлөрсөн цэгийн зэрэглэлд тавигдах шаардлагад нийцүүлэн техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчин, дотоод зохион байгуулалт, менежментийг бодлогыг Эрх бүхий этгээд боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

3.13. Эрх бүхий этгээд төвлөрсөн цэгийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн зохицуулах үүрэг бүхий талбайн зохицуулагч томилон ажиллуулна. Талбайн зохицуулагч нь дараах үүрэг хүлээнэ.

3.13.1. Төвлөрсөн цэгт хүлээн авсан хог хаягдлын тоо, хэмжээ, жин, ирсэн огноо, байршуулсан газрыг бүртгэх журнал, зураг дээр тухай бүр тэмдэглэх;

3.13.2. Хог хаягдлын нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, хөтлөх;

3.13.3. Ирсэн хог хаягдлыг асгах газрыг зааж өгөх;

3.13.4. Нэвчилтийн улмаас ус, хөрсний бохирдол үүсч байгаа эсэхэд байнга хяналт тавьж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр заасан арга хэмжээг гүйцэтгэх;

3.13.4. Хог хаягдал булшлах, хогийн цэгийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн зохицуулах;

3.14. Төвлөрсөн цэгийн ажиллах цагийн хуваарь, уг цэгт хүлээн авахгүй хог хаягдлын жагсаалт, шаардлагатай утасны дугаар, хог хаягдал хүлээн авах төлбөр тооцоотой холбогдолтой мэдээллүүдийг ил тод бичсэн байна.

3.15. Булшилсан хог хаягдал дотор хуримтлагдсан хийн даралтыг багасгах, хянах зориулалтаар гадагшлуулах хийн хоолой буюу агааржуулагчийг байрлуулна.

3.16. Гал түймрээс сэргийлэхийн тулд хог хаягдал аяндаа шатах эрсдлийг бууруулах зорилгоор талбайд байнга хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авна.

3.16. Агаарт аяндаа задардаг хог хаягдлыг хаалттай булшлах цэгт нэг хоногоос илүү хугацаагаар ил задгай байлгахыг хориглоно.

3.17. Хог хаягдал булшлах, зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгт ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн болон аюулгүй ажиллагааны нөхцлийг хангах асуудлыг Эрх бүхий этгээд хариуцна.

ДӨРӨВ. ТӨВЛӨРСӨН ХОГИЙН ЦЭГИЙГ ХААХ

4.1. Төвлөрсөн хогийн цэгийг дараах нөхцөл үүссэн тохиолдолд бүрэн хаах тухай шийдвэр гаргаж холбогдох эрх бүхий байгууллагад хангана.

4.1.1. Зөвшөөрөгдсөн зай талбайд хог хаягдал булшилж, нөөц газар талбайгүй болсон, талбай бүрэн дүүрсэн;

4.1.2. Байгаль орчны хяналт шинжилгээгээр хангалтгүй дүгнэлт удаа дараа авсан;

4.1.3. Байгаль экологийн өөрчлөлт орж, хөрс нурсан, газар хөдөлсөн, үер ус орсон нь цаашид ландфиллээр ашиглах боломжгүй болсон;

4.1.4. Хот, суурьшлын шинэ бүс болж хотын шинэ төлөвлөлтөд орсон;

4.1.5. Хүний эрүүл мэнд, амьтан, ургамал, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа болон үзүүлж болзошгүй нөхцөл үүссэн;

4.2. Төвлөрсөн хогийн цэгийг дараах нөхцөл үүссэн тохиолдолд хэсэгчлэн хаах тухай шийдвэр гаргаж холбогдох эрх бүхий байгууллагад хангана.

4.2.1. Ландфилл талбайн зарим хэсэгт хог хаягдал булшилж, тохижилт бүрэн хийн, нийтийн эзэмшлийн талбай болгох шаардлага хангасан,

4.2.2. Талбайн хэсэг газарт экологийн өөрчлөлт орж, хөрс нурсан, газар хөдөлсөн, үер ус орсон нь ландфиллийг бүрэн хаахгүйгээр хэсэгчлэн хаах боломжтой бол,

4.2.3. Дээд газраас буюу орон нутгийн Засаг даргаас хэсэгчлэн хаах чиглэл өгсөн, (Тухайн Засаг даргын чиглэлд хэсэгчлэн хаах болсон шалтгаан, үндэслэл, эдийн засаг, нийгмийн дүн шинжилгээ, холбогдох дээд шатны байгууллагын шийдвэр зэргийг дэлгэрэнгүй тусгасан байна.)

4.3. Төвлөрсөн хогийн цэгийг хаах нөхцөл бүрдсэн тохиолдолд дараах арга хэмжээг авна.

4.3.1. Төвлөрсөн хогийн цэгийг ажиллуулж, хог хаягдал булшлах үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд хаах болсон шалтгаан бүхий шийдвэр гаргана.

4.3.2. Ландфилл хаах болон хаасны дараах тохижилт, хяналтыг Төвлөрсөн хогийн цэгийг ажиллуулж, хог хаягдал булшлах үйл ажиллагаа эрхэлж байсан этгээд өөрөө болон гэрээгээр ландфилл хаах, хаасны дараа хяналт тавих эрх бүхий этгээд (цаашид Ландфилл хаах этгээд гэнэ)-ээр гүйцэтгүүлж болно. Ландфилл хаах этгээд хаах тухай хүсэлтийг энэ зааврын 4.3.1-д заасан шийдвэрийн хамт тухайн орон нутгийн Засаг даргад хүргүүлнэ. Хүсэлтэд дараах мэдээллийг тусгасан байна.

4.3.2.1. Хэсэгчлэн болон бүрэн хааж байгаа аль нь болох;

4.3.2.2. Хааж байгаа талбайн хэмжээ;

4.3.2.3. Хаах үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө (графикчилсан);

4.3.2.4. Байгаль орчны үнэлгээ болон мэргэжлийн хяналт шалгалт хийх төлөвлөгөө;

4.3.3. Хүсэлт хүлээн авсан орон нутгийн Засаг дарга ландфилл хаах Ажлын хэсгийг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Ажлын хэсэг нь тухайн орон нутгийн хог хаягдал хариуцсан мэргэжлийн хяналтын байцаагч, байгаль орчны байцаагч, Засаг даргын Ажлын албаны хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн зэрэг шаардлагатай албан тушаалтнаас бүрдэнэ.

4.3.4. Ландфилл хаах Ажлын хэсэг дараах ажлыг хийж хэрэгжүүлнэ.

4.3.4.1. Энэ зааврын 4.3.2.3-д заасан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаад хяналт тавих;

4.3.4.2. Энэ зааврын 4.3.2.4-д заасан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийх;

4.3.4.3. Хааж эхлэхээс дуусах хүртэл мэргэжлийн хяналтын явцын дүгнэлт тогтмол гаргаж, хаахад бэлэн болсон тохиолдолд нэгдсэн дүгнэлт гаргах;

4.3.4.4. Ландфилл хаах үед гарсан зөрчил, алдаа дутагдлыг засаж залруулах, сайжруулах зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах;

4.3.4.5. Мэргэжлийн зөвлөгөө, тусламж дэмжлэг үзүүлэх;

4.3.5. Энэ зааврын 4.3.3-д заасан ажлын хэсэг тухайн орон нутгийн Засаг даргад дараах баримт бичгийг хүргүүлнэ.

4.3.5.1. Энэ зааврын 4.3.2.3-д заасан төлөвлөгөөний хэрэгжилтэд тавьсан үнэлгээ,

4.3.5.2. Энэ зааврын 4.3.2.4-д заасан төлөвлөгөөний дагуу хийсэн хяналт шалгалтын мэдээ,

4.3.5.3. Мэргэжлийн хяналт, байгаль орчны дүгнэлт,

4.3.5.4. Ландфилл хаах үед өгсөн зөвлөмж, зөвлөгөө, тусламж, дэмжлэгийн мэдээ

4.3.6. Ландфилл хаах шийдвэрийг тухайн орон нутгийн Засаг дарга энэ зааврын 4.3.5-д заасан баримт бичгийг үндэслэн гаргана.

4.4. Төвлөрсөн хогийн цэгийг хаасны дараа дараах арга хэмжээг авна.

4.4.1. Ландфилл хаах этгээд ландфилл хааснаас хойш 5-10 жил тухайн газрын орчны тохижилтыг хариуцаж ажиллана.

4.4.2. Хаасан газрын байгаль орчны үнэлгээ, дүгнэлтийг Ландфилл хаах этгээд энэ зааврын 4.4.1-д заасан хугацаанд 2 жил тутамд хийлгэж, тухайн орон нутгийн Засаг даргад хүргүүлнэ.

4.4.3. Хаасан газрыг анх хаасан нөхцөл байдлаар хэвээр байлгахад Ландфилл хаах этгээд анхаарч ажиллана.

4.5. Хаасан ландфилл нь дараахь шаардлагыг хангасан байна.

4.5.1. Хучилтын хөрс эрүүл, зузааны хэмжээ 5-аас доошгүй метр байх;

4.5.2. Хөрс гулгахгүй, нурахгүй, шороо хийсэхгүй, бохир хөрс ил гарахгүй байх,

4.5.3. Урт хугацааны явцад хог хаягдал ил гарч ирэхгүй байх;

4.5.4. Булшилсан хог хаягдалд хими, физикийн өөрчлөлт орж, хөрс цөмрөх, нүх гарах, хөрс, гадаргуу өөрчлөгдөхгүй байх;

4.5.5. Хөрсийг бүрэн зүлэгжүүлж, шаардлагатай газар мод тарих, ландфиллийн онцлогоос хамаарч амралт зугаалгын газар болгож тохижуулах, гүйлтийн болон дугуйн зам тавих;

4.5.6. Үер, усны аюулаас бүрэн хамгаалж, хаалт хашлага, далан шуудуу татах;

4.5.7. Хог хаягдлаас үүсэх хийг аюулгүй байлгах нөхцөлийг бүрдүүлэх ;

4.6. Ландфиллийг хаасны дараа дараах мэдээг тухайн орон нутгийн Засаг даргад Ландфилл хаах этгээд хүргүүлнэ.

4.6.1. Хаасан газрын талбайн хэмжээ;

4.6.2. Булшилсан хог хаягдлын насжилт, хог хаягдлын бүтэц, найрлага, төрөл, хэмжээ;

4.6.3. Хучилтын хөрсний зузааны хэмжээ, хөрсний бүтэц, найрлага, онцлог;

4.6.4. Тарьсан зүлэг, ногоо, мод, бутны нэр төрөл, хэмжээ;

4.6.5. Хааснаас хойш хийх тохижилтын жилийн хугацаа, тохижилт хийх төлөвлөгөө, график, ажиллах хүчний мэдээ;

4.7. Тохижилт хийсэн мэдээ тайланг жилд нэг удаа тухайн орон нутгийн Засаг даргад Ландфилл хаах этгээд хүргүүлнэ.

ТАВ.БУСАД

5.1.Хог хаягдал булшлах, устгах байгууламж, төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байцаагч, байгаль орчны байцаагч, Хог хаягдлын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, байгаль хамгаалагчид хяналт тавина.

5.2. Орон нутгийн байгаль орчны алба нь аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан хөтөлбөрийн дагуу байгаль орчны шинжилгээг тусгайлан тогтсон газраас зургаан сард нэг удаа, бактерийн шинжилгээг гурван сард нэгээс доошгүй удаа хийж байна.

5.3. Энэ зааврыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэл эрүүгийн шинжтэй бол Эрүүгийн хуулийн, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Хог

хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.